



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар A/93

Мандалговь

Г Аймгийн Онцгой байдлын газартай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 , 34.2, Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаарын сарын 22-ны өдрийн A/175 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байгаа “Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 15 суманд зохион байгуулах” ажлыг аймгийн Онцгой байдлын газраар гүйцэтгүүлсүгэй.
2. Арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Онцгой байдлын газарт шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал)-д нарт үүрэг болгосугай.
3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн 2022 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр санхүүжих Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150208